



ҮАГ
Үндэсний аудитын газар

**МИАТ ХК-ийн аж ахуй, санхүүгийн
үйл ажиллагаа**



**Компанийн шийдвэр гаргах
түвшний албан тушаалд
сонирхлын зөрчил бүхий
хүмүүсийг томилон ажиллуулжээ**

**УИХ-ын Эдийн засгийн болон Дэд бүтцийн Байнгын хороодын саналаар хийсэн
аудитын тайлан**

Улаанбаатар 2006 оны 12 дугаар сар

ҮАГ -2/2006/08-ГА

Агуулга

	Агуулга	1
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгсийн жагсаалт	4
ҮАГ-ын хоёрдугаар газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
<i>Газрын захирал</i> <i>О.Мэндбаяр</i>	Бүлэг 1 Ерөнхий зүйл	6
<i>Аудитын менежер</i> <i>М.Давааням</i>		
<i>Ахлах аудитор</i> <i>С.Гансүх</i>	Бүлэг 2 МИАТ ХК-ийн орлого бүрдүүлэлт, авлага барагдуулалт	
<i>Аудитор</i> <i>А.Сүхбаатар</i> <i>И.Туяа</i>	<ul style="list-style-type: none">• Үнэ тарифыг хямдруулах бодлого баримтлаж байна	7
2006 оны 12 дугаар сар	<ul style="list-style-type: none">• Үйл ажиллагааны орлогын өсөлтөд зорчигчийн орлого гол нөлөө үзүүлжээ	7
Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:	<ul style="list-style-type: none">• Тийз борлуулалтыг гэрээт компаниудын ашиг сонирхолд нийцүүлжээ	8
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	<ul style="list-style-type: none">• Гэрээний биелэлтийг дүгнээгүй, гэрээнд заасан нөхөн төлбөрийг аваагүй байна	8
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<ul style="list-style-type: none">• Гэрээт агентуудад хяналт шалгалт хийгээгүй байна	8
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын</i> <i>4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6,</i> <i>Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i>	<ul style="list-style-type: none">• Компанийн удирдах албан тушаалд сонирхлын зөрчил бүхий хүмүүсийг томилсон байна	9
	<ul style="list-style-type: none">• Зорчигчийн суудал захиалга, тийз борлуулалтыг програмчлах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна	9
	<ul style="list-style-type: none">• Холбогдох журмыг зөрчиж, бусдад хөнгөлөлт үзүүлснээс МИАТ ХК 561,5 сая төгрөгийн орлого олох боломж алджээ	10
	<ul style="list-style-type: none">• Нойтон түрээсээр онгоц ашиглах гэрээгээр их хэмжээний алдагдал хүлээхээр байна	10

Агуулга

- Түрээсээр ашиглаж байгаа онгоцуудад өөрсдийн хүчээр засвар, техник үйлчилгээ хийж байгаа нь хэмнэлт гаргах нөхцөл бүрдүүлжээ 10
- Гадаадын агентуудтай тооцоо хийгээгүйгээс найдваргүй авлага нэмэгджээ 10
- Албан тушаалтнуудын буруу шийдвэрээс компанид хохирол учирсан байна 11

Бүлэг 3 **МИАТ ХК-ийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл**

- Баталсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс зардлын зарим зүйл анги их хэмжээгээр хэтэрч, хэмнэгджээ 12
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгийг худалдан авчээ 13

Бүлэг 4 **МИАТ ХК-ийн бараа материал, хөрөнгийн худалдан авалт, өглөгийн тооцоо**

- Худалдан авалтын шууд гэрээ байгуулснаас 400,0 сая төгрөг хэмнэх боломж алджээ 14
- Шунхлай ХХК ТС-1 маркийн шатахууны үнийг тодорхой үндэслэлгүй нэмжээ 14
- Удирдах ажилтнууд журам зөрчиж, өндөр үнэтэй орон сууц үнэ төлбөргүй авчээ 15
- Компанийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй шилжүүлжээ 15
- Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. 16

Бүлэг 5 **Төрийн өмчийн эд хөрөнгийн**

Агуулга

бүртгэл, ашиглалт, хамгаалалт

- ТӨХ хууль зөрчиж МИАТ ХК-д автомашин үнэгүй шилжүүлсэн байна 17
- Засгийн газрын шийдвэрийн дагуу хөрөнгө шилжүүлжээ 17

Дүгнэлт 19

Холбогдох байгууллагын санал 21

Зөвлөмж 23

Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ОУАТХ	Олон улсын агаарын тээврийн холбоо
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГХЯ	Гадаад хэргийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, хүндрэл бэрхшээл

УИХ-ын Эдийн засгийн болон Дэд бүтцийн (хуучин нэрээр) Байнгын хороодын санал, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу МИАТ ХК-ийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудит хийв.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт гаргахад энэхүү аудитын зорилт оршиж байв. Үүнд:

1. МИАТ ХК-ийн орлого бүрдүүлэлт, авлага барагдуулалт
2. МИАТ ХК-ийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын зарцуулалт
3. МИАТ ХК-ийн бараа материал, хөрөнгийн худалдан авалт, өглөгийн тооцоо
4. Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийн, тэднээс асуулга, лавлагаа авч, холбогдох мэдээллийг харьцуулж, байгууллагын 2005 оны ажлын төлөвлөгөө, санхүүгийн болон ажлын тайланг судлан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан шинжилгээ хийлээ.

Аудитаар МИАТ ХК-ийн 2005 оны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хамруулан үзэв. Ингэхдээ:

- Нойтон түрээсээр онгоц ашиглах гэрээний 2006 оны урьдчилсан гүйцэтгэлийг шалгав.
- Менежментийн гэрээгээр ажилласан Ирланд улсын удирдлагын багийн гүйцэтгэсэн ажлын үр дүн энэ аудитад хамрагдаагүй болно.
- Аудитын хамарсан хугацаанд шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнууд ажлаас өөрчлөгдсөн тул илэрсэн зөрчил, төлбөрийн талаар асууж, лавлагаа авч чадсангүй.
- Тооцооны авлагатай гадаадын агент, тус компанийн гадаадын Төлөөлөгчийн газруудыг шалгаж дүгнэлт өгөх бололцоо гарсангүй.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Ерөнхий зүйл

1.1 МИАТ компанийг Сайд нарын Зөвлөлийн (хуучин нэрээр) 1956 оны 272 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, ТӨХ-ны 2001 оны 413 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулжээ.

1.2 2005 оны байдлаар МИАТ ХК 12 хэлтэс, тасаг, 3 үйлчилгээний алба, гадаадын 5 улсын 6 хот дахь Төлөөлөгчийн газруудтай, бүгд 682 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж иржээ.

1.3 2002 оноос хойш тус компанид онгоцны парк шинэчлэл хийгдээгүй бөгөөд, 6 аймаг, ОХУ-ын Эрхүү хот руу өөрийн эзэмшлийн АН-26, гадаадын 7 улсад түрээсийн Аэробус-310-300, Боинг-737-800 онгоцоор нислэг үйлдэж байна.

1.4 Тус компанийн орон тоо ОУАТХ-ноос тодорхойлсон аргачиллын дагуу тооцоолсон дундаж хувь хэмжээ (1 том онгоцонд 200 орчим байх)-нээс 30 орчим хувиар илүү байна.

1.5 2000 оноос хойш тус компанийн удирдлага 5 удаа өөрчлөгдсөн бөгөөд ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг шийдвэр гаргах түвшний удирдлагын албан тушаалд томилж байжээ.

1.6 Дотоодын нислэгийн тариф хувийн хэвшлийн авиакомпанийн тарифаас дунджаар 25 хувиар доогуур батлагдсанаас МИАТ ХК жилд дотоодын зорчигч тээврээс 1,4 – 2,0 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байна.

1.7 МИАТ ХК-ийн 2004-2005 оны санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2004 он	2005 он	өөрчлөлт	
				тоогоор	хувиар
Аяллын тоо	тоо	2039	1288	-751	-36,8
Нислэгийн зам	мян.км	5763,6	6613,8	860,2	15,0
Зорчигчийн тоо	мян.хүн	254,2	213,8	-40,4	-15,9
Үүнээс: олон улсын	мян.хүн	162,3	178,4	16,1	9,9
Ачаа тээвэрлэлт	мян.тн	1,8	1,6	-0,2	-12,3
Суудал ашиглалт	Хувь	64,2	63,8	-0,4	-0,6
Нийт орлого	сая төг.	61250,2	70353,1	9102,9	14,9
Үүнээс: зорчигчийн	сая төг.	50477,9	56462,0	5984,1	11,9
Нийт зардал	сая төг.	59427,1	68031,8	8604,7	14,5
Татварын өмнөх ашиг	сая төг.	1823,1	2321,3	498,3	27,3
Орлогын татвар	сая төг.	619,5	1168,0	548,5	88,5
Цэвэр ашиг	сая төг.	1203,4	1153,3	-50,1	-4,2

1.8 2005 онд зорчигчийн болон нислэгийн тоо буурсан нь орон нутгийн нислэгт зөвхөн 1 онгоц үйлчлэх болж, чиглэлийн тоо цөөрсөнтэй холбоотой байна.

1.9 Гэвч гадаад нислэг, зорчин явагчдын тоо нэмэгдсэнээр үйл ажиллагааны орлого нийт дүнгээрээ 14,9 хувиар өсчээ.

Бүлэг 2

МИАТ ХК-ийн орлого бүрдүүлэлт, авлага барагдуулалт

Үнэ тарифыг хямдруулах бодлого баримталж байна

2.1 МИАТ ХК 2005 онд үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, суудал ашиглалтыг сайжруулах, үнэ, тарифыг хүн амын амьжиргааны түвшин, зах зээл, нислэгийн давтамжтай уялдуулах зорилгоор орон нутгийн болон олон улсын нислэгийн зорчигчийн тарифыг шинэчлэн баталж, олон улсын нислэгийн зорчигчийн тарифыг анх удаа "Airfare" системээр зарлажээ.

2.2 Ингэснээр нислэгээ эртнээс төлөвлөсөн зорчигчдод хямд тарифаар үйлчлэх, тийгийг автомат үйлдлээр бичих боломжийг бүрдүүлснээс гадна тусгай, түр, урамшууллын, транзит, 7 хоногийн, 7 хоногийн сүүлийн гаригуудын хөнгөлөлттэй, илүү тээш, дамнуургатай зорчигчийн зэрэг 14 төрлийн тариф мөрдүүлжээ.

Зорчигчоос авах дайны /YR/, шатахууны үнийн /YQ/ эрсдэлийн хураамжийг гүйцэтгэх захирлын 2005 оны Б\221 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлсэн байна.

2.3 2005 онд МИАТ ХК олон улсын нислэгийн үнэ тарифыг дунджаар 4-5 хувиар нэмэгдүүлжээ. Энэ тариф өрсөлдөгч ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсын агаарын тээврийн компаниудын тарифаас 6-44 хувиар хямд байна.

2.4 2005 оноос орлого хуваалцах тусгай гэрээний тариф \SPA\-ыг мөрдөж эхэлснээр олон улсын нислэгийн зорчигчийн тарифыг бууруулах боломж бүрдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Хойт Америк, Австрали, Зүүн өмнөд Азийн орнуудад зорчих орлого хуваалцах гэрээг 8 авиакомпанитай байгуулжээ.

Үйл ажиллагааны орлогын өсөлтөд зорчигчийн орлого гол нөлөө үзүүлжээ

2.5 Үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр харуулбал:

	Орлогын нэр	2004 гүйцэтгэл	2005 оны			өөрчлөлт /+ -/	
			төлөв лөгөө	гүйцэт гэл	эзлэх хувь	2004 оноос	Төлөвлө гөөнөөс
1	Зорчигч	51477.9	54362.4	56462.0	80.3	4984.1	2996.6
2	Илүү тээш	1036.0	1006.7	945.8	1.3	-90.2	-60.9
3	Ачаа	3289.8	3583.2	3143.2	4.5	-146.6	-440.0
4	Шуудан	291.0	277.8	375.1	0.5	84.1	97.3
5	Захиалгат	1322.1	947.1	2134.2	3.0	812.1	1187.1
6	Дайны/YQ/, шатахууны үнийн өсөлтийн/YR/ эрсдэлийн хураамж	1320.4	2526.6	3896.4	5.5	2576.0	1369.8
7	Бусад	2512.9	5142.5	3396.4	4.8	883.5	-1746.1
	Дүн	61250.1	67846.3	70353.1	100	9102.9	2506.8

2.6 МИАТ ХК олон улсын авиакомпаниудын холбооны суудал захиалгын GABRIEL системийг үндсэн сүлжээ болгон ашигладаг ба олон улсын хэмжээнд ашиглаж байгаа бусад сүлжээгээр дамжуулан суудал захиалга авч байна.

Тийз борлуулалтыг гэрээт компаниудын ашиг сонирхолд нийцүүлжээ

2.7 МИАТ ХК-ийн 2005 оны орлогын 33 хувийг дотоодын борлуулагч агентууд, 31 хувийг гадаадын борлуулагч агентууд, 20 хувийг гадаадын төлөөлөгчийн газрууд, 15 хувийг тус компанийн Суудал захиалга, борлуулалтын төв, 1 хувийг дотоодын төлөөлөгчийн газар бүрдүүлсэн байна.

2.8 Монголоос гадаадад зорчих зорчигч, тээвэрлэх ачааны тийзийн борлуулалтыг МИАТ ХК бие даан гүйцэтгэх боломжтой атал гэрээт агентуудаар дамжуулан хэрэгжүүлж иржээ. 2005 онд зорчигчийн тийз борлуулагч дотоодын 6 агентад борлуулалтын шимтгэлээр 1,0 тэрбум гаруй төгрөг төлжээ.

2.9 МИАТ ХК зорчигчийн тийз борлуулалтаар гадаадын 27, дотоодын 6 агенттай, ачаа, тээш илгээлтээр гадаадын 3, дотоодын 1 агенттай гэрээ байгуулахдаа хуулийн дагуу сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгоогүй бөгөөд байгуулсан гэрээнд:

- 2 талын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаагүй,
- МИАТ ХК-ийн зүгээс цуцлах эрхгүй, цуцалбал торгууль хүлээх,
- Суудал захиалгын олон улсын системийн ашиглалтын зардлыг төлөх үүргийг тусгаагүйгээс МИАТ ХК тэдгээр агентуудын өмнөөс тухайн зардлыг төлсөн зэрэг зөрчил илэрлээ.

2.10 Зарим гэрээлэгч эрсдэлээс хамгаалах зорилготой 100000 ам.долларын барьцаа хөрөнгийг холбогдох дансанд байршуулаагүй байна.

Гэрээний биелэлтийг дүгнээгүй, гэрээнд заасан нөхөн төлбөрийг аваагүй байна

2.11 Япон улсын нэр бүхий 7 компанитай сар, өдрөөр, тодорхой тооны суудлаар хөнгөлөлттэй тарифаар зорчигч явуулах /суудал блокдох/ гэрээ байгуулж, биелэлтийг дүгнээгүй байна. Компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн бол 1,7 тэрбум төгрөгийн орлого нэмж олох байжээ.

2.12 Дээрх 7 компаниас байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу ашиглаагүй суудлын төлбөр бүгд 383,8 сая төгрөгийг нөхөн тооцож аваагүйг аудитаар илрүүлэв.

Гэрээт агентуудад хяналт шалгалт хийгээгүй байна

2.13 2004 онд тус компанийн Суудал захиалга, борлуулалтын төвөөс дотоодын агентуудад хийсэн шалгалтаар хямдралтай тарифаар бичсэн тийзээс шимтгэл тооцсон, валютын ханшийг зах зээлийн ханшаас доогуур тогтоосон, бичигдсэн билетийг гараар зассан, тийзэнд хураамжийн задаргааг буруу бичсэн зэрэг 20 гаруй төрлийн зөрчил илэрсэн байхад зөрчлийг арилгуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

2.14 2005 онд гэрээт агентуудад хяналт шалгалт хийгээгүй байна.

Компанийн удирдах албан тушаалд сонирхлын зөрчил бүхий хүмүүсийг томилсон байна

2.15 Гэрээт агентуудад тавих хяналт, шаардлага суларсан нь зарим гэрээт агентуудын гүйцэтгэх захирлыг МИАТ компанийн удирдах албан тушаалд томилон ажиллуулсантай холбоотой байж болох юм. Тухайлбал, Коммерийн асуудал эрхэлсэн дэд захирлаар ачааны борлуулагч агент Монголиан Эйр Транс /МАТ/ ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хоролсүрэнг (одоо Европын бүсийг хариуцсан захирлын алба хашиж байгаа бөгөөд 4500 еврогийн цалинтай), зорчигчийн тийз борлуулагч агент Эйр маркет ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Хатанбаатар, Эйр нетворк ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Энхсайхан нарыг Маркетингийн хэлтсийн даргаар томилон ажиллуулжээ.

2.16 ОУАТХ-оос агаарын тээврийн гэрээт агентуудад үйлчилгээний орлогоос тооцож олгох хувь хэмжээг 1-9 хувь байх, хувь хэмжээг тогтоохдоо гүйцэтгэх ажлын хэмжээнд тулгуурлах зарчмыг баримтлах зөвлөмж гаргасан. Гэтэл МИАТ ХК-ийн удирдлагууд гэрээт агентуудад олгох үйлчилгээний орлогоос шимтгэж олгох хувь хэмжээг гүйцэтгэх ажлын хэмжээтэй уялдуулаагүй, шууд өндөр хувь хэмжээгээр тогтоож, олгож иржээ. Тухайлбал, 2005 онд зорчигчийн тийз борлуулагч гадаадын агентуудад 9 хувийн, дотоодын агентуудад 6 хувийн, ачааны борлуулагч агент Монголиан Эйр Транс ХХК -д 100 мянган төгрөгөөс дээш ачаа тээвэрлүүлсэн бол 9 хувийн шимтгэл олгохоор тогтоожээ.

Зорчигчийн суудал захиалга, тийз борлуулалтыг програмчлах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна

2.17 ОУАТХ-оос ойрын 2 жилд агаарын тээврээр зорчигчдын 70-80 хувийг интернетээр суудал захиалах, тийз худалдан авах үйлчилгээнд хамруулах зорилт тавьжээ.

2.18 Дээрх зорилтын хүрээнд хийх ажлын эхлэл болгож МИАТ ХК Япон улсын Централ Ази Центр компанитай гэрээ байгуулан ажилласнаар 2005 онд 52 зорчигчид интернетээр тийз борлуулжээ.

2.19 Гэвч энэ үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай болох, сүлжээний хүчин чадлыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна.

2.20 Түүнчлэн интернетээр суудал захиалах, тийз борлуулах журам боловсруулаагүй, олон нийтэд сурталчлах ажил хангалтгүй хийгдэж байна.

2.21 Тийз борлуулалтын орлогыг ARIS програм ашиглан бүртгэж байгаа боловч энэ нь нягтлан бодох бүртгэлийн бичилт хийхэд хүндрэлтэй, зөвхөн орлогын мэдээллийг гаргах зориулалттайгаас шат дамжлагыг нэмэгдүүлж, санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын ачааллыг ихэсгэж байна. Тийзийн борлуулалтыг зөв, шуурхай бүртгэх програм хангамж нэвтрүүлэх шаардлагатай байна.

Холбогдох журмыг зөрчиж, бусдад хөнгөлөлт үзүүлснээс МИАТ ХК 226,3 сая төгрөгийн орлого олох боломж алджээ

2.22 2005 онд гүйцэтгэх захирал асан Б.Цогоо “МИАТ ХК-ийн нислэгээр хөнгөлөлттэй тийзээр зорчих зөвшөөрөл олгох журам”-ыг зөрчиж гадны 476 хүнд 50-100 хувийн үнийн хөнгөлөлттэй тийз олгож, 226,3 сая төгрөгийн орлого олох боломж алджээ.

2.23 Хөнгөлөлттэй тийзийн борлуулалтыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэж тайлагнаагүй байна.

Нойтон түрээсээр онгоц ашиглах гэрээгээр их хэмжээний алдагдал хүлээхээр байна

2.24 МИАТ ХК 2006 оны зун гадаадын жуулчдыг шуурхай тээвэрлэх зорилгоор Итали улсын Блю Панорама Эйрлайнз авиакомпанитай нойтон түрээсээр онгоц авч ашиглах гэрээ байгуулжээ.

2.25 Онгоц түрээсээр ашиглах асуудлыг ЗТАЖЯ, ТӨХ, тус компанийн ТУЗ дэмжиж, холбогдох шийдвэр гарган зөвшөөрөл олгосон байна.

2.26 Түрээсийн гэрээг урьдчилан дүгнэж үзэхэд МИАТ ХК 2006 онд 2,8 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр байна.

2.27 Энэ нь гарах зардал, гэрээний эдийн засгийн үр ашгийг буруу тооцоолсонтой холбоотой байна. Их хэмжээний алдагдалтай гэрээ байгуулсан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох шаардлагатай байна.

2.28 ЗТАЖЯ, ТӨХ, тус компанийн ТУЗ ч их хэмжээний алдагдалтай гэрээнд хяналт тавиагүй, хайхрамжгүй хандаж, хариуцлага алдсан байна.

Түрээсээр ашиглаж байгаа онгоцуудад өөрсдийн хүчээр засвар, техник үйлчилгээ хийж байгаа нь хэмнэлт гаргах нөхцөл бүрдүүлжээ

2.29 МИАТ ХК А310-300, Б737-800 онгоцнуудын “С” хэлбэрийн засвар үйлчилгээг хийх эрхтэй болжээ.

2.30 Үүний үр дүнд засварын зардлаас жилд 1,3 сая ам.долларын хэмнэлт гаргасан төдийгүй бусад орны авиакомпанийн онгоцонд “С” хэлбэрийн засвар, үйлчилгээ хийж, нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлжээ.

Гадаадын агентуудтай тооцоо хийгээгүйгээс найдваргүй авлага нэмэгджээ

2.31 2005 онд МИАТ ХК-ийн авлага 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 5,1 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь:

- онгоцны нисэгч нарын дүрэмт хувцас, зорчигчийн хатуу тийзийн захиалга он дамжсанаас 200 сая төгрөг,
- онгоцны сэлбэгийн гаалийн татварын авлага 400 сая төгрөг,

- он дамжиж дансанд орсон гадаад, дотоодын агентуудын 12 дугаар сарын орлого 600 сая төгрөг,
- татварын байгууллагатай хийх нэмэгдсэн өртгийн албан татварын тооцооны үлдэгдэл 600 сая төгрөг болсноос тус тус шалтгаалсан байна.

2.32 1,5 тэрбум төгрөгийг найдваргүй авлагаар тайлагнасны 650,6 сая төгрөг буюу 43 хувь нь гадаад, дотоодын агентуудаас авах борлуулалтын орлогын үлдэгдэл авлага байна. Агентуудаас авах найдваргүй авлагыг хүснэгтээр харуулбал:

№	Агентийн нэр	Улсын нэр	Авлага үүссэн он	Авлага /сая.төг/	тайлбар
1	Mongolian EZA	Монгол	2001	153,8	Эзэн нь олдохгүй болсон
2	G.S.A in Seoul	БНСУ	1999	233,9	дампуурсан
3	G.S.A Duayen tours	Турк	1999	158,6	дампуурсан
4	Key Aviation Amsterdam	Нидерланд	2001	51,5	дампуурсан
5	Euro Asia servise	Япон	2000	52,8	дампуурсан
	Дүн			650,6	

2.33 Борлуулагч агентуудаас эрсдэлээс хамгаалах барьцаа хөрөнгийг гаргуулж, дансанд байршуулаагүй, байгуулсан гэрээг дүгнээгүй, дотоод хяналт, шаардлага сул, ажлын хариуцлагагүй байдлаас найдваргүй авлагын хэмжээ цаашид ч нэмэгдэх эрсдэл байна.

Албан тушаалтнуудын буруу шийдвэрээс компанид хохирол учирсан байна

2.34 2002 онд компанийн дэд захирлаар ажиллаж байсан Ц.Баатарсайхан Япон улсын Глобал компанитай байгуулсан гэрээний тарифыг дур мэдэн өөрчилснөөс, МИАТ ХК-д 8,2 сая төгрөгийн алдагдал учирсныг Япон улсын Глобал компаниас авах авлагаар бүртгэжээ. Компанийн тухай хуулийн 81.3-т "... компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцна", 82.1-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан ... хууль бус үйл ажиллагаа явуулсан бол ... учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна" гэж заасны дагуу уг алдагдлыг нөхөн төлүүлэх шаардлагатай гэж үзэв.

2.35 МИАТ ХК-ийн ТУЗ-ийн 2004 оны 19/4 дүгээр тогтоолоор БНХАУ-ын Бээжин хот дахь Төлөөлөгчийн газарт 50 ам метр талбай бүхий албан байр худалдаж авах зөвшөөрөл олгосны дагуу БНХАУ-ын Хуа Юаун проперти компанид байрны урьдчилгаа 48368 ам.долларыг шилжүүлж, урьдчилж төлсөн төлбөрийн дансанд бүртгэсэн байна. Уг байрыг авах талаар гэрээ байгуулж, арга хэмжээ аваагүй албан тушаалтантай хариуцлага тооцож, байгууллагыг хохиролгүй болгох, авлагыг нягтлан бодох бүртгэл, тайланд зохих ёсоор бүртгэж, залруулах шаардлагатай байна.


Бүлэг 3

МИАТ ХК-ийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл

Баталсан төлөвлөгөөг мөрдөөгүйгээс зардлын зарим зүйл анги их хэмжээгээр хэтэрч, хэмнэгджээ.

3.1 ТӨХ-ны 2005 оны 197 дугаар тогтоолоор МИАТ ХК-ийн үйл ажиллагааны зардлыг 66,4 тэрбум төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэл 1,6 тэрбум төгрөгөөр хэтэрч, 68 тэрбум төгрөг болжээ.

3.2 Үйл ажиллагааны шууд зардлын бүтцийг графикаар харуулбал:



3.3 Тус компани 2005 онд цалингийн жишигт өөрчлөлт оруулж, бүтцийн өөрчлөлт хийхдээ зардлын төлөвлөгөөг тодотгож, залруулаагүйгээс зарим нэр төрлийн зардал их хэмжээгээр хэтэрсэн буюу хэмнэгджээ.

3.4 Зардлын төлөвлөгөөг үндэслэл, тооцоо муутай боловсруулжээ. 2005 онд үйлчилгээний зардал 783,4 сая төгрөг, зорчигчийн хүнс 902,1 сая төгрөг, нисэх бүрэлдэхүүний зардал 1116,9 сая төгрөг, борлуулагч агентуудын шимтгэлийн зардал 491,5 сая төгрөг, нисэх бүрэлдэхүүний сургалтын зардал 822,7 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 487,9 сая төгрөг, бусад зардал 3442,2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн бол шатах, тослох материал 1034,6 сая төгрөг, аэронавигацийн зардал 723,6 сая төгрөг, засвар үйлчилгээний зардал 1339,0 сая төгрөг, нисэх бүрэлдэхүүний тогтмол цалингийн зардал 546 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд газрын тоног төхөөрөмжийн зардал, түрээсийн татвар, болзошгүй тохиолдолд гэж 1739,5 сая төгрөг төлөвлөсөн боловч зарцуулаагүй байна.

3.5 Зардлын гүйцэтгэлд зохих ёсоор хяналт тавиагүй бөгөөд ирүүлсэн мэдээг зөвхөн нэгтгэх замаар тайлан мэдээ гаргаж ирсэн байна. 2005 онд Ховд аймаг дахь салбарын нярав их хэмжээний шатахуун дутагдуулсан нь хяналт шалгалт тогтмол хийж байгаагүйг харуулж байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж, мөрдөөгүйгээс нягтлан бодогч ажил гүйлгээг замбараагүй бүртгэж ирсэн бөгөөд энэ нь зардлын зүйл анги буруу тайлагнагдахад хүргэжээ.

3.7 2005 онд дотоодын агентуудын суудал захиалгын зардал 151,7 сая төгрөгийг МИАТ ХК төлжээ. Дотоодын агентуудтай байгуулсан гэрээнд суудал захиалгын олон улсын системийг ашигласны зардлыг төлөх талаар тусгаагүй учир нөхөн төлүүлэх нь зүйтэй байна.

3.8 Үндсэн үйлдвэрлэлийн зардал хүрэлцэхгүй, санхүүжилтийн эх үүсвэр улирлын чанартай, банкнаас их хэмжээний зээл авч зээлийн хүү болон ханшийн зөрүүгийн алдагдалд орж байгааг үл ойшоон төлөвлөгдөөгүй арга хэмжээнд хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаадаагүй хөрөнгийг худалдан авчээ

3.10 Тус компанийн ТУЗ-ийн 2004 оны 23/4 дүгээр тогтоол, ТӨХ-ны 2005 оны 197 дугаар тогтоолоор МИАТ ХК-ийн 2005 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 981,5 сая төгрөгөөр баталжээ. Хэдийгээр хөрөнгө оруулалтын зардал хэмнэгдсэн мэт харагдаж байгаа боловч зарим зардлыг батлагдсанаас өөр зориулалтаар зарцуулж хэтрүүлжээ.

3.11 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулан өөрт шаардлагатай гэж худалдан авсан хөрөнгийг гадны байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлсэн, оронд нь өндөр үнэтэй, засвар хийх шаардлагатай хөрөнгө авч, байгууллагад хохирол учруулсан зөрчил илэрлээ.

3.12 Ажиллагсдын үйлчилгээний зориулалтаар Старикс маркийн 3 микроавтобусыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган худалдан авахдаа нэгийг нь нөгөө хоёртой тэнцэхүйц үнээр буюу тэдгээрээс хоёр дахин илүү үнээр худалдан авчээ.

3.13 2005 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ачаа тээшийн трактор, чиргүүл, тавцан, автомашин, зорчигчийн шат зэргийг авахаар тусгасан боловч тэдгээр техникийг хэрэглэх газрын үйлчилгээний алба бүтцийн өөрчлөлтөөр ИНЕГ-т шилжсэнээс худалдан авах шаардлагагүй болсон байна.

3.14 ТӨХ, компанийн ТУЗ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгоогүй, хариуцлагагүй хандсанаас төлөвлөөгүй хөрөнгө авчээ. Тухайлбал, худалдан авахаар батлагдсан 19 нэр төрлийн үндсэн хөрөнгийн оронд 82 ширхэг компьютерийг 97,9 сая төгрөгөөр, хөргөгч, принтер, сканер, камер, хувилагч, гар утас зэргийг 33,8 сая төгрөгөөр, багаж хэрэгсэл, тавилга эд хогшлыг 94,1 сая төгрөгөөр худалдан авч, орон сууц авах зардлыг 596,9 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

Бүлэг 4

МИАТ ХК-ийн бараа материал, хөрөнгийн худалдан авалт, өглөгийн тооцоо

Худалдан авалтын шууд гэрээ байгуулснаас 400.0 сая төгрөг хэмнэх боломж алджээ

4.1 2005 онд 21486.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсны 88,0 хувийг шатахуун, 9,1 хувийг хангамжийн зүйлс, 2,9 хувийг сэлбэг хэрэгсэл эзэлж байна.

4.2 18,9 тэрбум төгрөгөөр шатахуун худалдан авсны 53 хувь буюу 10,4 тэрбум төгрөгийн шатахууныг гадаадын зах зээлээс, 47 хувь буюу 8,5 тэрбум төгрөгийн шатахууныг дотоодын зах зээлээс худалдан авчээ.

4.3 Онгоцны ТС-1 шатахуун, автомашины А-80, АИ-92 бензин, дизель түлшийг нийлүүлэх гүйцэтгэгчийг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулалгүй, Шунхлай групп ХХК-тай шууд худалдан авах гэрээ байгуулжээ. Шунхлай групп ХХК тус компанийн шатахууны хэрэгцээний 70 хувийг дангаараа хангаж байсан бөгөөд 2005 онд 5,4 тэрбум төгрөгийн ТС-1 онгоцны шатахуун, 30,3 сая төгрөгийн А-80 бензин, 29,1 сая төгрөгийн АИ-92 бензин, 232,8 сая төгрөгийн дизелийн түлш нийлүүлжээ.

4.4 Дотоодын зах зээлийн тухайн үеийн дундаж ханштай харьцуулж үзвэл Шунхлай групп ХХК-ийн шатахуун борлуулсан үнэ хамгийн өндөр байсан бөгөөд энэ үнийн зөрүүгээс МИАТ ХК ойролцоогоор 400,0 сая төгрөг хэмнэх боломж алджээ.

Шунхлай ХХК ТС-1 маркийн шатахууны үнийг тодорхой үндэслэлгүй нэмжээ

4.5 Шунхлай ХХК МИАТ ХК-д ТС-1 маркийн шатахуун нийлүүлэх гэрээний үнийг 4 удаа өөрчлөхдөө нефть бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулалгүй, тодорхой үндэслэлгүйгээр 23-40 хувиар нэмэгдүүлжээ. Үүнд, Шунхлай ХХК 2 удаа үнэ нэмэхдээ ОХУ-ын нефть бүтээгдэхүүний импортын татвар нэмэгдсэн гэсэн үндэслэл гаргасан, үлдсэн 2 удаад нь ямар ч шалтгаан үндэслэлгүй нэмжээ. АМГТХЭГ-аас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2005 онд ТС-1 маркийн шатахууны импортын болон гаалийн татвар 1-19 хувиар өсчээ.

Аудитын явцад МИАТ ХК Шунхлай ХХК-иас шатахуун авах гэрээгээ цуцалж, 2006 оны 11 дүгээр сард ТС-1 маркийн онгоцны шатахуун нийлүүлэх тендер зарлан гүйцэтгэгчээр А-Жет Лимитед ХХК-ийг шалгаруулжээ.

4.6 Олон улсын зорчигч үйлчилгээний болон цайны газрын зориулалттай 924,6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа мөн л холбогдох хуулийг зөрчиж, бэлтгэн нийлүүлэгчийг тендергүй сонгожээ.

Коммерийн асуудал эрхэлсэн дэд захирал Ч.Хоролсүрэн болон Катерингийн төвийн дарга Б. Оюунбаяр нар 44 аж ахуйн нэгжтэй шууд худалдан авалтын гэрээ байгуулахдаа худалдан авалтын үнийн дүнг зориуд багасгаж нэг компанитай ижил төрлийн бараа материал худалдан авах 3-4 тусдаа гэрээ байгуулах, хэрэгцээ

шаардлага хангахгүй бараа материал их хэмжээгээр зах зээлийн дундаж ханшаас өндөр үнээр худалдан авах зэрэг зөрчил гаргасан байна.

Удирдах ажилтнууд журам зөрчиж, өндөр үнэтэй орон сууц үнэ төлбөргүй авчээ

4.7 2005 онд 300,0 сая төгрөгөөр орон сууц авахаар төлөвлөгөөнд тусгагдсан боловч гүйцэтгэлээр 596,9 сая төгрөг хэтрүүлжээ. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийлгүй, ТУЗ-ийн шийдвэргүйгээр Тайж трейд ХХК-аас 6 орон сууцыг 134,3 сая төгрөгөөр, Пума ХХК-аас 15 орон сууцыг 323,4 сая төгрөгөөр, Гангар-Инвест ХХК-аас 14 орон сууцыг 199,8 сая төгрөгөөр, Пума ХХК-аас 4 орон сууцыг 239,4 сая төгрөгөөр, бүгд 39 орон сууцыг 896,9 сая төгрөгөөр худалдан авахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй байна.

4.8 2005 оны үйл ажиллагааны жилийн эцсийн үр дүнг харгалзан компанийн гүйцэтгэх захирал, дэд захирлууд, санхүүгийн хэлтсийн дарга нарт орон сууц худалдан авах зөвшөөрлийг 2005 оны 2\1061 тоот албан бичгээр ТӨХ-ны төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга Ц.Нанзаддорж олгожээ. Энэ нь гүйцэтгэх захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй, ТУЗ-ийг төлөөлөх чадамжгүй шийдвэр юм.

4.9 Пума ХХК-иас 239,4 сая төгрөгөөр худалдан авсан 4 орон сууцыг МИАТ ХК-д 1 жил 6 сар ажилласан 4 удирдах ажилтанд үнэ төлбөргүй олгожээ. Энэ нь тус компанийн орон сууц хуваарилж, эзэмшүүлэх журамд таваас дээш жил тасралтгүй ажилласан ажилтанд орон сууц олгоно гэж заасныг зөрчжээ. Түүнчлэн журам зөрчиж, урьд өмнө орон сууц авсан 3 хүнд орон сууц олгожээ.

Аудитын явцад дэд захирал асан Ч.Хоролсүрэн орон сууцаа буцаан өгөх хүсэлтээ компанийн захиргаанд өгч, бусад 3 орон сууцны асуудлыг шийдвэрлүүлэхээр компани цагдаагийн байгууллагад ханджээ.

Компанийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй шилжүүлжээ

4.10 “НАМХӨХХАЙРХАН” ХХК-иас БНСУ-д үйлдвэрлэсэн СОНАТА-5 маркийн 2 суудлын автомашиныг бүгд 32,1 сая төгрөгөөр сонгон шалгаруулалтгүй, гэрээ байгуулалгүй шууд худалдан аваад Шүүхийн ерөнхий зөвлөл болон Улсын дээд шүүхэд үнэ төлбөргүй шилжүүлжээ. Ингэхдээ ТӨХ-ны тогтоолыг үндэслэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газрын зөвшөөрөл олгосон тохиолдолд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр үнэ төлбөргүй шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн учир буцаан авах нь зүйтэй гэж үзэв.

4.11 Тус компани худалдан авалт, хангамжийн үйл ажиллагааг төвлөрүүлэн зохион байгуулаагүй нь үр ашиггүй зардал гарах нэг шалтгаан болж байна. 2005 оны байдлаар хангамжийн хэлтэс үйлчилгээний автомашины техник, шатахуун болон үнэт цаас, дүрэмт хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас, аж ахуйн холбогдолтой бараа материалыг, техникийн алба онгоцны сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, шатахууныг, катерингийн төв зорчигчийн хоол, үйлчилгээний болон цайны газрын зориулалтын бараа материалыг тус тус худалдан авч иржээ.

Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна

4.12 2005 оны тайлан тэнцлээр нийт 28,2 тэрбум төгрөгийн өглөгтэй гарч, урьд оноос богино хугацаат өр 4,5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, урт хугацаат өр 4,4 тэрбум төгрөгөөр буурчээ.

4.13 Нийт өглөгийн 50,7 хувь буюу 14,3 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 49,3 хувь буюу 13,9 тэрбум төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Тайлант онд богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь:

- 2004 оны орлогын албан татварын өглөг 843,0 сая төгрөгийг өр төлбөрт тусгаагүй байсныг залруулсан,
- 2005 оны орлогын албан татвар 1168,0 сая төгрөг, түрээсийн орлогын албан татвар 944,1 сая төгрөг, нийт 2955,1 сая төгрөгийг татварын өглөгт тусгасан,
- Орон сууц худалдан авахад 657 сая төгрөгийн зардлыг барилгын гүйцэтгэгч байгууллагад өгөх өглөгт тусгасан,
- Агентуудаас гэрээний эрсдэлээс хамгаалах зорилгоор байршуулсан 967 сая төгрөгийг өглөгөөр тайлагнасан зэргээс шалтгаалсан байна.

4.14 Урт хугацаат өр төлбөр буурсан нь Аэробус 310-300 маркийн онгоцны санхүүгийн түрээсийн 2005 оны төлбөрийг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

4.15 Өр төлбөрийн үлдэгдлийг холбогдох байгууллагатай нь тооцоо нийлж баталгаажуулаагүй, данс бүртгэлд өр төлбөрийг дутуу тусгасан, өр төлбөр барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Бүлэг 5

Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт

5.1 МИАТ ХК-ийн 2005 оны үндсэн хөрөнгийн хөдлөлийг хүснэгтээр харуулбал:

	Үндсэн хөрөнгийн нэр	2005.01.01		Нэмэгдсэн	Хорогдсон	2005.12.31	
		дүн	дүнд эзлэх%			дүн	дүнд эзлэх%
1	Онгоц , тоног төхөөрөмж	32047,1	78,9		91,4	31955,7	81,0
2	Барилга байгууламж	3587,9	8,8	76,0	220,7	3443,2	8,7
3	Автомашин, бусад ТТ	1291,9	3,2	192,0	613,7	870,2	2,2
4	Эд хогшил бусад	3712,6	9,1	719,3	1228,3	3203,6	8,1
	Дүн	40639,5	100,0	987,3	2154,1	39472,7	100,0

/сая.төгрөгөөр/

5.2 2005 оны эцсийн байдлаар МИАТ ХК 39,5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, үүнээс 81 хувь нь агаарын хөлөг, нислэгийн техник, төхөөрөмж байна.

5.3 Хөрөнгийн түрээсээр ашиглаж байгаа Аэробус-310 онгоцыг 26696.6 сая төгрөгийн үнэтэйгээр балансад тусгажээ.

ТӨХ хууль зөрчиж МИАТ ХК-д автомашин үнэгүй шилжүүлжээ

5.4 ТӨХ-ны 2005 оны 173 дугаар тогтоолоор ГХЯ-ны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 52176,0 мянган төгрөгийн үнэтэй Ланд ровэр маркийн суудлын автомашиныг балансаас балансад үнэ төлбөргүй шилжүүлж авсан байна. Автомашиныг үнэгүй шилжүүлэх талаар Засгийн газрын шийдвэр гараагүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газрын зөвшөөрөл олгосон тохиолдолд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр үнэ төлбөргүй шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

5.5 Гадаадын төлөөлөгчийн газруудын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй байсан 93,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансад бүртгэж залруулжээ.

Засгийн газрын шийдвэрийн дагуу хөрөнгө шилжүүлжээ

5.6 “Иргэний нисэхийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2001 оны 104 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн В-д “... иргэний нисэхийн салбарт өмчийн олон хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газрын үйлчилгээ, шатахуун... зэрэг нийтлэг үйлчилгээг зах зээлийн харилцаанд нийцүүлэн зохион байгуулах” гэж заасныг үндэслэн ТӨХ-ны 2005 оны 333 дугаар тогтоолоор МИАТ ХК-аас 1269,0 сая төгрөгийн газрын үйлчилгээний

зориулалттай барилга байгууламж, автомашин, механизм, шатахууны лаборатори, техник хэрэгслийг ИНЕГ-т балансаас балансад үнэгүй шилжүүлжээ.

5.7 АН-2 онгоцны парк ашиглалтыг сайжруулах, үйл ажиллагааг нь тогтвортой, үр ашигтай явуулах зорилгоор Засгийн газрын 2005 оны 163 дугаар тогтоолоор МИАТ ХК-иас салган “МИАТ-Агросервис” ТӨҮГ байгуулжээ. Энэ тогтоолыг үндэслэн ЗТАЖ-ын сайд, ТӨХ-ны даргын 149/151 дүгээр тушаалаар МИАТ Агросервис ТӨҮГ-т эд хөрөнгө хүлээлгэн өгөх комисс томилон, 564,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлжээ.

5.8 МИАТ ХК-д ашиглалтгүй үндсэн хөрөнгө байхгүй бөгөөд үндсэн хөрөнгийг жилийн эцэст тоолон үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Дүгнэлт

МИАТ ХК-ийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- 1) Дотоодын нислэгт зөвхөн 1 онгоц үйлчлэх болсноос зорчигч, нислэгийн тоо буурахад хүрсэн боловч гадаад нислэгийн тоо, зорчигчийн өсөлт орлого нэмэгдэхэд нөлөөлжээ.
- 2) Гэрээт агентууд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлснээс 1,7 тэрбум төгрөгийн, холбогдох журам зөрчиж хөнгөлөлттэй тийз олгосноос 226.3 сая төгрөгийн орлого олох боломж алдсан бөгөөд нойтон түрээсээр онгоц ашиглах гэрээ байгуулж, хэрэгжүүлснээс /урьдчилсан байдлаар/ 2,8 тэрбум төгрөгийн алдагдал хүлээхээр болжээ.
- 3) Удирдлагын тогтворгүй байдал нь олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, үйл ажиллагааны журам, зааврын хэрэгжилт болон хариуцлагын тогтолцоог сулруулж, компанийн алс хэтийн хөгжил, хөрөнгө оруулалт, санхүү, маркетингийн цогц, тогтвортой бодлогод сөргөөр нөлөөлжээ.
- 4) Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд иж бүрэн програм хангамж нэвтрүүлж, зорчигчийн тийз борлуулах үйл ажиллагаанд интернетийн сүлжээг ашигласнаар хүн хүч, өртөг зардлыг бууруулах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох боломж байна.
- 5) МИАТ ХК-ийн шийдвэр гаргах түвшний албан тушаалд сонирхлын зөрчил бүхий хүмүүсийг томилон ажиллуулж, компанийн эрх ашигт нийцэхгүй гэрээ байгуулж, их хэмжээний зардал хэмнэх боломж алдсан төдийгүй, хувийн компаниудын өмнөөс олон улсын сүлжээ ашигласны зардлыг төлж, хувийн байгууллагын эрх ашигт нийцсэн бодлого хэрэгжүүлж байжээ.
- 6) Гэрээт агентуудтай байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй, агентуудаас хөрөнгө байршуулах ажил хангалтгүй байгаа нь цаашид найдваргүй авлага нэмэгдэх эрсдэлийг ихэсгэж байна.
- 7) Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, эд хөрөнгө худалдан авах, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг зөрчих явдал нийтлэг болж, зах зээлийн үнэ ханшаас өндөр үнээр болон шаардлага хангахгүй бараа материал их хэмжээгээр худалдан авч, төрийн өмч хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаад ТӨХ, МИАТ ХК-ийн ТУЗ хяналт тавьж, зохих арга хэмжээ аваагүй, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.

- 8) ТӨХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг удаа дараа зөрчсөн байна.

МИАТ ХК-ийн 2005 оны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар 567.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1315,5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Холбогдох байгууллагын санал

Зам, тээвэр,
аялал
жуулчлалын
яам

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ


**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-64-06, Факс: 31-06-12
E-mail: info@mrtt.pmis.gov.mn; http://www.mrtt.pmis.gov.mn

2007.01.05 № 2/29
танай 2006.12.27-ны № 455 -Т

МИАТ ХК-д хийсэн аудитын
тайлангийн тухай

Танай газраас МИАТ ХК-ийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайланд МИАТ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, компанийн удирдлагын алдаатай шийдвэр гаргаснаас төрийн өмчийн компанид ихээхэн хэмжээний хөрөнгийн хохирол учруулсан тухай дурьдаад, тодохой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Төрийн өмчийн хороо, тус компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал нарт өгснийг дэмжиж байна.

Тус яамны эрхлэх асуудлын хүрээнд уг компанийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил, дутагдлыг арилгуулах талаар анхаарч ажиллах болно.

МИАТ ХК-ийн Итали улсын Blue Panorama Airlines компаниатай байгуулсан "Нойтон түрээсийн гэрээ"-ний хэрэгжилт, үйл ажиллагаанд Улсын Мэргэжлийн хяналтын газраас хийсэн шалгалтын дүнг манай яаманд ирүүлснийг МИАТ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн бөгөөд, ирүүлсэн хариуг үүгээр хавсарган хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудас.

 ДЭД САЙД  Г.ШИЙЛЭГДАМБА

МИАТ ХК


МИАТ
ХУВЬЦААТ КОМПАНИ


МИАТ ХУВЬЦААТ КОМПАНИ
210134 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45,
Утас: 37-99-35, 32-02-21, Факс: 37-99-19, 37-98-77,
Site: ULNDDOM, ULNTTOM,
<http://www.miat.com>

2007. 01.03 № 06/14
танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МИАТ ХК-ийн 2005 оны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн тайланг хүлээн авч танилцлаа. Тайланд тусгагдсан дүгнэлт зөвлөмжийг хүлээн авч цаашдын үйл ажиллагаандаа анхаарч ажиллахаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,


САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД
ЗАХИРАЛ *Ж.ГАНБОЛД*
VXMO058 2613747

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

1. Төрийн өмчийн хорооны дарга, МИАТ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Сугарт:

- 1.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж байх,
- 1.2. Зорчигчийн суудал захиалга, тийз борлуулалт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж, зардлыг хямдруулах, хөрөнгө оруулалт, маркетингийн цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх,
- 1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг МИАТ ХК-ийн хэмжээнд мөрдүүлснээр хөрөнгө нөөц арвилан хэмнэх нөхцөл бүрдүүлэх,
- 1.4. Тийзийн үнийг хөнгөлж буй асуудлыг зохих журмын дагуу хянаж, шийдвэрлүүлэх,
- 1.5. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлын мөрөөр шуурхай, арга хэмжээ авч, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох

2. МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбилэгт:

- 2.1. Тийз борлуулах гэрээт агентуудад олгох шимтгэлийг гүйцэтгэх ажлын хэмжээ, байршуулсан барьцаа хөрөнгийг харгалзан ялгавартай тогтоох, олон улсын суудал захиалгын системийн зардлыг гэрээт агентуудтай байгуулсан гэрээнд тодорхой тусгах,
- 2.2. Шийдвэр гаргах түвшний албан тушаалд сонирхлын зөрчил бүхий хүмүүсийг томилон ажиллуулах явдлыг таслан зогсоох,
- 2.3. Зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэл, тайлагналын программ хангамж нэвтрүүлэх,
- 2.4. МИАТ ХК-ийн онгоцны бүх төрлийн шатахууны бэлтгэн нийлүүлэгчийг тендерээр сонгон шалгаруулж, шатахууны үнийг дорвитой бууруулах арга хэмжээ авах,
- 2.5. Агентуудын гүйцэтгэх ажил, тавигдах шаардлага, тур оператор компаниудыг агентаар ажиллуулах нөхцөл, онцлогийг тусгасан сонгон шалгаруулах журам боловсруулж, мөрдөж ажиллах,

- 2.6. Гэрээт агентууд болон харьяа төлөөлөгчийн газруудад тавих дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх,
- 2.7. Хангамж, худалдан авалтыг компанийн хэмжээнд төвлөрсөн байдлаар гүйцэтгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- 2.8. Харилцагчид болон бэлтгэн нийлүүлэгчидтэй үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх